



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/280

Сүхбаатар сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 "ч", 30 дугаар зүйлийн 30.1.5, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын "Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрт 2020 онд ашигт малтмал олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг газар дээр нь шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:


- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

Гишүүд:

- Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, уул уурхайн асуудал хариуцсан мэргэжилтэн
- Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч
- Хараа, Ерөө, Сэлэнгэ, Орхон голын сав газрын захиргааны ус ашиглагч хариуцсан мэргэжилтэн
- Тухайн сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч
- Тухайн сумын тухайн газар нутгийг хариуцсан байгаль хамгаалагч
- Нөлөөллийн бүсэд оршин сууж буй иргэний төлөөлөл /тохиролцооноор/

2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг шалгаж, дүгнэлт гаргах ажлыг 2020 оны 11 дүгээр сарын 30-ны дотор зохион байгуулж, төсөл хэрэгжүүлэгчийн төлөөллийг байлцуулан хянаж, баталгаажуулсан дүгнэлтээ 12 дугаар сарын 30-ны дотор байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /З.Түвшинтөгс/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx